



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/37

Рашаант сум

**Соёлын төвийн ёс зүйг хариуцсан
ажилтныг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх заалт, Төрийн захиргаа болон үйлчилгээний ажилтны ёс зүйн журмын 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын төвийн дарга Лхагвасүрэнгийн Баярцэнгэлийг байгууллага дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, асуудлыг хариуцуулахаар томилсугай.

2. Л.Баярцэнгэлийн байгууллагын ёс зүйн асуудал хариуцан ажиллах хугацааны нэмэгдэл урамшууллыг Төрийн албаны ёс зүйн тухай хуулийг үндэслэн үндсэн цалингийн 10%-аар тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Амартүвшин)-д зөвшөөрсүгэй.

3. Байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын мэдээ, тайлан, судалгааг хугацаанд нь гаргаж харьяа байгууллагад хүргүүлэх, ёс зүй зөрчлийн тухай мэдээг харьяалах албан тушаалтанд танилцуулах мэдээлэх ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА  Б.АЛТАНГЭРЭЛ

